



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/107

Сангиндалай

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9 дэх заалт, “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 266 дугаар тогтоол “Хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” Дундговь аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторийн 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 23-52, 23-23 бүртгэлийн дугаартай шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Сангиндалай багийн Замын гашуун, Гэрчулуун нутаг дэвсгэрт бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүссэн тул 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл 15 километр 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Бог малын гоц халдварт мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-т үүрэг болгосугай.

3. Хорио цээрийн бүсэд хүн амын хөдөлгөөнд хяналт тавьж, хэв журам сахиулж ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч хошууч (Б.Амарбаяр), Эрэн хайх аврах салбарын дарга, Онцгой байдлын ахлах дэслэгч (Б.Энхтөр) нарт үүрэг болгосугай.

4. Хорио цээрийн бүсэд хийх халдваргүйжилт, дархлаажуулалтыг чанартай зохион байгуулахыг Элбэгдалай мал эмнэлэгт, тандалтын судалгаа гаргаж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт, шаардлагатай мал сүргийг бүтэн хамруулахыг багийн Засаг дарга (Ж.Өлзийжаргал)-д, Голомт болон сэжигтэй бүсэд хэчнээн айл байгааг тогтоож бог малын бүх тоог гаргаж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тархвар зүйч (Т.Машбат) нарт үүрэг болгосугай.

482302213

6. Хорио цээрийн бүсэд байгаа малчин өрхийн хүн амын эрүүл мэндийн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Насандэлгэр)-т үүрэг болгосугай.

7. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог гаргаж холбогдох газарт тайлагнаж, шийдвэрлэх асуудлыг шуурхай зохион байгуулахыг санхүүгийн албаны дарга (А.Соёл-Эрдэнэ)-д даалгасугай.

8. Ард иргэд малчдад бог малын мялзан өвчний талаарх урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан (Б.Өнөрбилэг), Нийгмийн эрүүл мэндийн ажилтан (Б.Бүрэнжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ